



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/72/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор
2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор: П.Амаржаргал

Утас: 88106992 Цахим хаяг: amar_802002@yahoo.com

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	12
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
3.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
3.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗООНОЗ
ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВИЙН
ДАРГА С.БААСАНХҮҮ
ТАНАА

2019.02.25 № 2/68

танай _____-ны № _____-г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Зооноз өвчин судлалын төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Зооноз өвчин судлалын төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Зооноз өвчин судлалын төвийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод

D:\Amaraa\amaraa\2019\5. СТА явц\2. Zoonoz\Зооноз Аудитын гэрчилгээ.docx

2519118

хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн дарга С.Баасанхүү-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 25-наас 2019 оны 01 дүгээр сарын 28-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 56 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төв нь “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага болох шалгуурыг үе шаттай хэрэгжүүлэх, зоонозын өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээг авах эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах.” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх.

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн яамны сайдын тушаал, шийдвэр

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" санхүүгийн программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 373,8 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 5,7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын төвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын төвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа, зөрчилтөйд залруулах асуудал гараагүй болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	9,2	Цалингийн зардлаас түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон мөн сахилгын шийтгэлтэй байхад Эрүүл мэндийн газрын даргын албан тоотоор үр дүнгийн урамшуулал олгосон.
	Дүн	1	9,2	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидлаар хүргүүлэв.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Байхгүй

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1094,3 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 329,3 сая төгрөг буюу 97,8 хувьтай байгаа нь 2018 онд 322,1 сая төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулан 7,2 сая төгрөг төвлөрүүлэн шилжүүлсэн байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно. Шилэн дансны цахим мэдээллийн санд төсөв гүйцэтгэлтэй холбоотой нийт мэдээллээс Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр) гэсэн мэдээллийг 7 дугаар сард хугацаа хоцрон мэдээлсэн, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авахтай холбоотой мэдээллийн Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Сар бүр) гэсэн мэдээллийг 7-р сард, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр) гэсэн мэдээллийг 1-р сард хугацаа хоцрон мэдээлсэн, бусад төрлийн 60-н мэдээ тус бүрийг хуулийн хугацаандаа бүрэн оруулсан байна.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмжийг хэрэгжүүлэн, холбогдох хууль тогтоомжийн заалтыг мөрдөн ажилласан байна.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн БНА-2019/72/СТА-ТШЗ

болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянхонгор аймгийн Зооноз өвчин судлалын төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу санхүүжүүлсэн эсэхийг анхан шатны баримттай тулган шалгахад төсөвт суулган батлуулаагүй байж цалингийн зардлаас албан хаагчдад түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон, сахилгын шийтгэлтэй байхад дээд газрын даргын тоотой үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон зөрчил илэрлээ

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16.5.5, Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 6-р хавсралтын 5 дугаар заалтыг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулаагүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Цалингийн зардлыг зориулалтын дагуу зарцуулж, төлөвлөөгүй зардлыг санхүүжүүлэхгүй байх, сахилгын шийтгэлтэй албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгохгүй байх.

Зөвлөмжийн мөрөөр хийж гүйцэтгэсэн ажлын 2019.04.15-ны дотор ирүүлэх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 04 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>49,518,190.88</u>	<u>52,748,205.40</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.01	00.01
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.01	00.01
3121	Төгрөг	00.01	00.01
31211	Төрийн сангийн харилцах	00.01	00.01
33	АВЛАГА	00.00	223,351.25
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	223,351.25
34	УРЬДЧИЛГАА	394,653.00	394,653.00
3471	Урьдчилгаа тооцоо	394,653.00	394,653.00
34713	Цалингийн урьдчилгаа	394,653.00	394,653.00
35	БАРАА МАТЕРИАЛ	49,123,537.87	52,130,201.14
351	Түүхий эд материал	25,382,108.45	30,503,040.71
35110	Тусгай зориулалттай материал	17,406,665.02	19,645,665.02
35130	Эм боох материал	7,975,443.43	10,857,375.69
354	Хангамжийн материал	23,741,429.42	21,627,160.43
35410	Бичиг хэргийн материал	2,632,246.40	3,273,616.40
35420	Аж ахуйн материал	8,905,568.03	9,807,403.03
35430	Сэлбэг хэрэгсэл	3,840,600.00	108,500.00
35440	Түлш, шатах тослох материал	537,825.00	1,543,901.00
35450	Барилгын засварын материал	1,868,149.99	1,062,700.00
35470	Бусад хангамжийн материал	5,957,040.00	5,831,040.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,133,126,987.82</u>	<u>1,026,350,968.83</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,133,126,987.82	1,026,350,968.83
392	Биет хөрөнгө	1,130,008,096.09	828,112,391.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,567,230,645.00	774,963,748.73
39202	Хуримтлагдсан элэгдэл	-507,324,641.03	-1,483,724.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	28,680,000.00	28,680,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-28,680,000.00	-28,680,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	140,180,617.08	136,209,507.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-79,536,793.80	-92,614,560.25
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,720,812.00	16,084,558.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,466,046.89	-10,183,308.05
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,991,872.39	18,967,485.59
39215	Хуримтлагдсан элэгдэл	-13,788,368.66	-13,831,316.06
393	Биет бус хөрөнгө	3,118,891.73	198,238,577.79
39301	Програм хангамж	4,068,855.70	4,068,855.70
39302	Хуримтлагдсан элэгдэл	-949,963.97	-1,830,277.91
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	196,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,182,645,178.70</u>	<u>1,079,099,174.23</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>320,380.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	320,380.00	00.00
413	Өглөг	320,380.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,182,324,798.70</u>	<u>1,079,099,174.23</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,182,324,798.70	1,079,099,174.23

Баянхонгор аймгийн Зооноз өвчин судлалын төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	231,624,333.39	427,624,333.39
51101	Өмч: - төрийн	231,624,333.39	427,624,333.39
512	Хуримтлагдсан үр дүн	950,700,465.31	584,991,353.84
51210	Өмнөх үеийн үр дүн	950,700,465.31	950,700,465.31
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-365,709,111.47
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	00.00	66,483,487.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,182,645,178.70	1,079,099,174.23

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	346,754,508.00	372,691,664.28
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,023,800.00	43,314,964.28
120	Нийтлэг татварын бус орлого	98,600.00	565,277.28
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	98,600.00	565,277.28
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	98,000.00	565,277.28
122	Тусламжийн орлого	18,925,200.00	42,749,687.00
122001	Хандив тусламж /дотоод/	18,925,200.00	42,749,687.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	327,730,708.00	332,517,850.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	322,654,400.00	329,376,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	322,654,400.00	329,376,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	5,076,308.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5,076,308.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	376,164,966.34	370,663,356.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	355,406,368.10	370,663,356.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	355,406,368.10	363,412,245.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	216,192,001.89	227,941,999.21
210101	Үндсэн цалин	185,245,256.89	176,732,289.21
210102	Нэмэгдэл	13,970,275.00	9,913,056.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	21,265,634.00
210104	Урамшуулал	16,976,470.00	20,031,020.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,084,414.69	27,419,148.25
210201	Тэтгэврийн даатгал	26,084,414.69	27,419,148.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,516,200.00	32,164,787.00
210301	Гэрэл, цахилгаан	1,126,703.00	1,591,556.00
210302	Түлш, халаалт	29,127,327.00	29,668,511.00
210303	Цэвэр, бохир ус	2,262,170.00	904,720.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,521,016.18	12,705,176.48
210401	Бичиг хэрэг	1,158,520.00	2,170,530.00
210402	Тээвэр, шатахуун	7,884,004.00	7,220,224.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,658,695.18	1,546,857.48
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	67,500.00	165,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,752,297.00	1,602,565.00

Баянхонгор аймгийн Зооноз өвчин судлалын төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативт зардал	10,385,168.88	3,855,510.52
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,187,168.88	3,855,510.52
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,198,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,615,000.00	7,326,249.99
210601	Багаж, техник, хэрэгсэл	710,400.00	470,400.00
210604	Урсгал засвар	4,904,600.00	6,855,849.99
2107	Томилолт, зочны зардал	4,100,900.00	3,933,100.00
210702	Дотоод албан томилолт	4,100,900.00	3,933,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,210,160.00	1,069,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	99,000.00	99,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	207,900.00	429,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	188,000.00	193,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,500.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	443,000.00	314,000.00
210807	Газрын төлбөр	221,760.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,781,506.46	46,997,273.95
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,781,506.46	46,997,273.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,758,598.24	7,251,111.31
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,776,949.00	00.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,076,308.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,700,641.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,981,649.24	7,251,111.31
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,981,649.24	7,251,111.31
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-29,410,458.34	2,028,307.57
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	367,737,419.04
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	5,678,350.88
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	362,059,068.16
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-29,410,458.34	365,709,111.47

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	327,731,308.00	329,376,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	600.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	600.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	600.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	327,730,708.00	329,376,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	322,654,400.00	329,376,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	322,654,400.00	329,376,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	5,076,308.00	00.00

Баянхонгор аймгийн Зооноз өвчин судлалын төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5,076,308.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	327,731,308.00	328,492,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	327,731,308.00	328,492,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	306,972,709.76	321,241,588.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	215,871,621.89	228,262,379.21
210101	Үндсэн цалин	184,924,876.89	177,052,669.21
210102	Нэмэгдэл	13,970,275.00	9,913,056.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	21,265,634.00
210104	Урамшуулал	16,976,470.00	20,031,020.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,084,414.90	27,642,499.50
210201	Тэтгэврийн даатгал	26,084,414.69	27,642,499.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,516,200.00	32,164,787.00
210301	Гэрэл, цахилгаан	1,126,703.00	1,591,556.00
210302	Түлш, халаалт	29,127,327.00	29,668,511.00
210303	Цэвэр, бохир ус	2,262,170.00	904,720.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,323,270.18	14,995,457.48
210401	Бичиг хэрэг	1,401,350.00	2,612,400.00
210402	Тээвэр, шатахуун	8,090,000.00	8,226,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,658,695.18	1,546,857.48
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	67,500.00	214,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,105,725.00	2,395,900.00
2105	Нормативт зардал	6,654,243.00	8,241,165.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,392,243.00	6,002,165.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,262,000.00	2,239,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,497,400.00	4,933,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	700,000.00	2,811,500.00
210604	Урсгал засвар	4,797,400.00	2,121,700.00
2107	Томилолт, зочны зардал	4,100,900.00	3,933,100.00
210702	Дотоод албан томилолт	4,100,900.00	3,933,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,226,660.00	1,069,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	99,000.00	99,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	207,900.00	429,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	188,000.00	193,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,500.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	459,500.00	314,000.00
210807	Газрын төлбөр	221,760.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	698,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	698,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,758,598.24	7,251,111.31
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,776,949.00	00.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,076,308.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,700,641.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,981,649.24	7,251,111.31

Баянхонгор аймгийн Зооноз өвчин судлалын төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,981,649.24	7,251,111.31
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	884,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	884,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	884,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	884,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	884,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-884,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.01	00.01
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.01	00.01

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	231,624,333.39	00.00	950,700,465.31	00.00	1,182,324,798.70
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	231,624,333.39	00.00	950,700,465.31	00.00	1,182,324,798.70
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	66,483,487.00	00.00	00.00	66,483,487.00
Тайлант үеийн үр дүн	196,000,000.00	00.00	-365,709,111.47	00.00	-169,709,111.47
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	427,624,333.39	66,483,487.00	584,991,353.84	00.00	1,079,099,174.23

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	322,654,400.00	314,672,750.76	329,376,700.00	322,125,588.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	322,654,400.00	314,672,750.76	329,376,700.00	322,125,588.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	313,954,400.00	306,972,109.76	329,376,700.00	322,125,588.69

Баянхонгор аймгийн Зооноз өвчин судлалын төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	221,277,200.00	215,871,621.89	229,252,800.00	228,262,379.21
210101	Үндсэн цалин	186,931,300.00	184,924,876.89	175,901,400.00	177,052,669.21
210102	Нэмэгдэл	11,676,600.00	13,970,275.00	22,278,300.00	9,913,056.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	00.00	16,498,300.00	21,265,634.00
210104	Урамшуулал	22,669,300.00	16,976,470.00	14,574,800.00	20,031,020.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,640,500.00	26,084,414.69	29,802,900.00	27,642,499.50
210201	Тэтгэврийн даатгал	15,540,300.00	26,084,414.69	29,802,900.00	27,642,499.50
210202	Тэтгэмжийн даатгал	2,220,000.00	00.00	00.00	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,996,100.00	00.00	00.00	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	444,000.00	00.00	00.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,440,100.00	00.00	00.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,331,200.00	32,516,200.00	34,733,900.00	32,164,787.00
210301	Гэрэл, цахилгаан	954,300.00	1,126,703.00	1,010,600.00	1,591,556.00
210302	Түлш, халаалт	28,021,900.00	29,127,327.00	31,368,300.00	29,668,511.00
210303	Цэвэр, бохир ус	2,355,000.00	2,262,170.00	2,355,000.00	904,720.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,792,500.00	14,322,670.18	16,456,000.00	15,055,457.48
210401	Бичиг хэрэг	450,800.00	1,400,750.00	450,800.00	2,612,400.00
210402	Тээвэр, шатахуун	13,105,400.00	8,090,000.00	13,315,900.00	8,226,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	455,700.00	1,658,695.18	455,700.00	1,546,857.48
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	147,000.00	67,500.00	600,000.00	214,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,633,600.00	3,105,725.00	1,633,600.00	2,455,900.00
2105	Нормативт зардал	6,656,700.00	6,654,243.00	8,242,800.00	8,241,165.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,363,900.00	5,392,243.00	5,950,000.00	6,002,165.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,292,800.00	1,262,000.00	2,292,800.00	2,239,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,511,900.00	5,497,400.00	4,366,400.00	5,757,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	998,500.00	700,000.00	998,500.00	3,420,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	00.00	250,000.00	215,000.00
210604	Урсгал засвар	4,513,400.00	4,797,400.00	3,117,900.00	2,121,700.00
2107	Томилолт, зочны зардал	4,105,300.00	4,100,900.00	4,105,300.00	3,933,100.00
210702	Дотоод албан томилолт	4,105,300.00	4,100,900.00	4,105,300.00	3,933,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,911,700.00	1,226,660.00	2,416,600.00	1,069,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,911,700.00	1,226,660.00	00.00	00.00

Баянхонгор аймгийн Зооноз өвчин судлалын төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	99,000.00	99,000.00	99,000.00	99,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	207,900.00	207,900.00	430,000.00	429,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	237,600.00	188,000.00	237,600.00	193,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,500.00	50,500.00	51,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	772,200.00	459,500.00	1,050,000.00	314,000.00
210807	Газрын төлбөр	445,500.00	221,760.00	450,000.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	99,000.00	00.00	99,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	727400.00	698000.00	0.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	727,400.00	698,000.00	00.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8700000.00	7700641.00	0.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,700,000.00	7,700,641.00	00.00	00.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	322,654,400.00	314,672,750.76	329,376,700.00	322,125,588.69
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	322,654,400.00	314,672,750.76	329,376,700.00	322,125,588.69
131001	Улсын төсвөөс санхүүжих	322,654,400.00	314,672,750.76	329,376,700.00	322,125,588.69
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.01	00.00	00.01
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.01	00.00	00.01
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28.00	00.00	28.00	28.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	28.00	28.00	28.00	28.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	29.00	29.00	29.00	29.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	19.00	19.00	19.00	19.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.00	10.00	10.00	10.00